

**ГАДААДЫН ИРГЭН, ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД  
ГАЗАР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

\_2017\_ оны \_01\_ сарын \_11\_ өдөр

\_\_Мандал\_\_ сум

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол Улсын Газрын тухай хууль, \_\_Сэлэнгэ\_\_ аймаг /нийслэл/-ийн \_\_Мандал\_\_ сум /дүүрэг/-ын Засаг даргын 2017\_ оны \_01\_ -р сарын \_03\_ ны өдрийн \_02\_\_ тоот шийдвэрийг үндэслэн газар өмчлөгчийг төлөөлж \_\_Мандал\_\_ сум /дүүрэг/-ын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан \_\_Баатарсайхан овогтой \_\_Булганхангай\_\_ газар ашиглагчийг төлөөлж, Бороо гоулд ХХК засгийн газартай харилцах асуудал эрхэлсэн захирал \_\_Д\_овогтой \_\_Сандаг\_нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

- 1.1. газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг;
- 1.2. газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт;
- 1.3. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт;

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ \_\_585,63\_\_ /га/. Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт	Тухайн зориулалтаар ашиглах газрын хэмжээ
1. __Ашигт малтмал олборлах__	__585,63__ /га/
2. __бусад__	_____ /га/
3. _____	_____ /га/
4. _____	_____ /га/
5. _____	_____ /га/

2.2. Газрын төлбөрийн хэмжээ:

Нэгжийн үнэ \_\_8000\_\_ төгрөг /үсгээр \_\_ төгрөг \_\_/

Бүгд үнэ \_\_4685040\_\_ төгрөг /үсгээр \_\_ төгрөг \_\_/

Үүнээс:

1-р улиралд \_\_\_\_\_ төг

3-р улиралд \_\_\_\_\_ төг

2-р улиралд \_\_\_\_\_ төг

4-р улиралд \_\_\_\_\_ төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар ашиглуулагчийн

\_\_\_\_\_ Төрийн банк 130000943 \_\_\_\_\_ тоот дансанд шилжүүлж байна.

/Банкны салбарын нэр, дансны дугаар/

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар ашиглагч хүлээнэ.

### **Гурав. Газар ашиглагчийн эрх, үүрэг**

- 3.1. гэрээний нөхцлийн дагуу газрыг ашиглах;
- 3.2. газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах;
- 3.3. гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах;
- 3.4. газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;
- 3.5. төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 3.6. газар өмчлөгчөөс газрын ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 3.7. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх;
- 3.8. холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

### **Дөрөв. Газар ашиглуулагчийн эрх, үүрэг**

- 4.1. газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах;
- 4.2. уг газрыг ашиглуулахын зэрэгцээ дараахь шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй.

Үүнд:

\_\_\_\_\_Газрын төлбөрийг жилд нэг удаа төлөх\_\_\_\_\_

4.3. "Газрын тухай" хуулийн 35.3.1.-35.3.6.-д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

- 4.4. газар ашиглуулах гэрээг жил бүр дүгнэх;
- 4.5. холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

### **Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт**

5.1. Газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл ГТХ-ийн 47-р зүйлийн дагуу /Газар ашиглах эрх дуусгавар болоход хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол бусад эд хөрөнгө өмчлөгч этгээдийн тэрхүү хөрөнгөө тухайн газар дээр ашиглах эрх дуусгавар болно./шийдвэрлэнэ.

5.2. энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ГТХ-ийн 48,49-р зүйлийн дагуу шийдвэрлэнэ. \_\_\_\_\_

\_\_\_\_\_ тус тус болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.3. гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл:

## Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2. Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж сумын Засаг даргын захирамж өдрөөс эхлэн \_\_\_5 /Таван/\_\_\_/үсгээр/ жилийн хугацаатай байгуулав.

6.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Сэлэнгэ аймгийн Мандал сумын ЗДТГ-ын Газрын даамал  
Б.Булганхангай /70367039/

Газар ашиглуулагч \_\_\_\_\_

Оршин суугаа газрын хаяг: УБ, ЧД, 1-р хороо Бодь цамхаг 11 давхар  
Ашиглах газрын хаяг: Хэрх 4-р баг Өнжин уул

Газар ашиглагч \_\_\_\_\_

Регистр /улсын бүртгэл/- ийн дугаар

2	0	9	4	5	3	3			
---	---	---	---	---	---	---	--	--	--

Харилцах дансны дугаар\_\_ Төрийн сан банк

Харилцах утас\_\_\_\_\_99110927\_\_\_\_\_

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар өмчлөгчийг төлөөлж

Газар ашиглагчийг төлөөлж

Засгийн газартай харилцах асуудал  
эрхэлсэн захирал Д.Сандаг

\_\_Сэлэнгэ\_\_ аймаг/нийслэл/-ийн

\_\_Мандал\_\_ сум /дүүрэг/-ын

газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан


\_\_Баатарсайхан\_\_ овогтой \_\_Булганхангай\_\_

/гарын үсэг/ \_\_\_\_\_ /тамга/



/гарын үсэг/ \_\_\_\_\_

/тамга/



Энэхүү гэрээний нэг хувийг 280 гэрээний дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт хадгалав.